

## 2014 ОНЫ 11 сард арилжаалах ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоол болно Сангийн яамны үнэт цаас бүртгүүлэх тухай хүсэлтийг үндэс болгон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 169 тоот тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 100.0 тэрбум төгрөгийн үнэт цаасын үнэт цаасны жагсаалтандаа бүртгэн авч дараах нөхцлөөр үнэт цаасны анхдагч арилжааг хийхээр болсон байна.

### ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

1. Үнэт цаас гаргагчийн нэр: Монгол Улсын Сангийн яам
2. Үнэт цаас гаргах зорилго: Монгол Улсын төсвийн алдагдлыг Санхүүжүүлэх
3. Үнэт цаасны санал болгох хүрээ: Олон нийтэд санал болгох
4. Үнэт цаасны төрөл: Засгийн газрын энгийн үнэт цаас
5. Нэрлэсэн үнэ: 100,000 төгрөг
6. Нийт гаргах тоо: 1,000,000 ширхэг
7. Нийт үнийн дүн: 1,000,000,000,000 төгрөг
8. Үнэт цаасны үзүүлэлт:

№	ЗГҮЦ-ны төрөл	Тоо хэмжээ /ширхэг/	Үнийн дүн /сая төгрөг/	Хугацаа /7 хоног/	Хүү төлөгдөх хэлбэр	Захиалга эхлэх өдөр	Арилжаа хаах өдөр
1	ЗГЭБ-Б-12-274	1,000,000	100 000.0	12	Хямдруулалттай	2014.10.29	2014.11.04
2	ЗГЭБ-Б-52-275	954 980	95 498.0	52	Сар бүр	2014.11.05	2014.11.11
3	ЗГЭБ-Б-12-276	952 676	95 267.6	12	Хямдруулалттай	2014.11.12	2014.11.18
4	ЗГЭБ-Б-28-277	-	-	28	Хямдруулалттай	2014.11.19	2014.11.25

9. Хүүгийн хувь хэмжээ: Долоо хоног бүр арилжигдах Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаасны хүүгийн хувь хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкинд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүү байна. Хэрэв Монголбанкны тухайн долоо хоногийн арилжаа цуцлагдсан тохиолдолд ижил хугацаатай ЗГҮЦ-ны өмнөх арилжааны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогдоно.

10. Захиалга авах хугацаа: Монголын хөрөнгийн бирж нь тус арилжааны саналыг хуанлийн 6 хоногийн турш авна.

Захиалга хүлээн авах цаг: Лхагва гарагт – 14:00- 16:00 цагт

Пүрэв гараг- Дараа долоо хоногын даваа гарагт- 10:00-16:00 цагт

Мягмар гарагт – 10:00-11:00 цагт

11. Арилжаа хийгдэх: Монголын хөрөнгийн биржийн арилжааны системд нийт захилагыг хүлээн авсны дараа Сангийн яамнаас хувиарлалтыг хийнэ.

12. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн 389 тоот тогтоол болон “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2014 оны 10 сарын 23-ны өдрийн 169 тоот тушаал гарч бүртгэгдсэн.